

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2026/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Арвайхээр хот
2025 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn
Аудитын менежер: П.Хорлоосүрэн
Утас: 70323833 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.com
Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг
Утас: 70323108 Цахим хаяг:
Erdenetsetsegb@audit.gov.mn
Аудитор: Э.Энхбаяр
Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА Ч.ГАНХУЯГ ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Араайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

Ддд. дд-10 № 88
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 25,933.1 мянган төгрөгөөр өссөн нь албан хаагчдын албан томилолтын өглөг 10,943.4 мянган төгрөг, тээвэр шатахууны өглөг 4,011.1 мянган төгрөг, байрны түрээсийн өглөг 4,444.2 мянган төгрөгийг өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 19 зорилт төсөл, 38 арга хэмжээ төлөвлөж 90.1 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6225020202

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

| | Үзүүлэлт | 2024.12.31 | 2025.12.31. |
|--|--|-------------------|------------------|
| Санхүүгийн байдлын тайлан | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 87,486.1 | 596,507.2 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 181,954.0 | 154,387.2 |
| | Нийт хөрөнгийн дүн | 269,440.1 | 750,894.4 |
| | Нийт өр төлбөрийн дүн | - | 6,841.8 |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 269,440.1 | 724,961.3 |
| | Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 269,440.1 | 750,894.4 |
| Санхүүгийн үр дүнгийн тайлан | | | |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 2,300,990.9 | 1,918,046.7 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 2,293,828.7 | 1,486,439.9 |
| | Үйл ажиллагааны үр дүн | 7,162.1 | 431,606.8 |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | 77,050.4 | - |
| | Үйл ажиллагааны нийт үр дүн | 69,888.2 | 431,606.8 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | | | |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 339,328.3 | 269,440.1 |
| | Тайлант оны үр дүн | (69,888.2) | 455,521.2 |
| | Эцсийн үлдэгдэл | 269,440.1 | 724,961.3 |
| Мөнгөн гүйлгээний тайлан | | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 1,935,010.8 | 998,893.5 |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 1,924,206.3 | 994,006.2 |
| | Үйл ажиллагааны ЦМГ | 10,804.5 | 4,887.3 |
| | Хөрөнгө оруулалтын ЦМГ | (10,804.5) | (4,887.3) |
| | Санхүүгийн ажиллагааны ЦМГ | - | - |
| | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлан | | | |
| | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 279,974.3 | 332,283.5 |
| | Урсгал зардал | 279,974.3 | 332,283.5 |
| | Хөрөнгийн зардал | - | - |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 279,974.3 | 332,283.6 |
| | Улсын төсвөөс санхүүжих | 279,974.3 | 332,283.6 |
| | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | - | - |

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 732.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснээс аудитын явцад алдааг бүрэн залруулж, цаашид ижил төрлийн алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөн тусалсан.

Үүнд: Аймгийн өвс тэжээлийн нөөцийг “Бусад хангамжийн материал” дансанд буруу бүртгэсэн бөгөөд уг алдааг алдаа, зөрчлийн дүнгийн ангилалд хамруулаагүй болно..

Аудитаар зөрчил илрээгүй.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй

3.2 Албан шаардлага

Зөрчил илрээгүй

3.3 Зөвлөмж

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6.4.5.-д заасан орлогын 16 гүйлгээ, хөрөнгө мөнгөтэй холбоотой 2 шийдвэрийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд нь шилэн дансны цахим системд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх шаардлагыг ханган ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | /сая төгрөгөөр/ | | | | Зөвлөмж | |
|---|------------|-------|-----------------------------------|-----|--------------------------|-------|-----------------|-------|-----|-----|---------|-----|
| | | | | | | | Үүнээс | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аймгийн өвс тэжээлийн нөөцийг зориулалтын дансанд бүртгээгүй. | 1 | 432.8 | | | 1 | 432.8 | 1 | 432.8 | | | | |
| Өвс тэжээлийн нөөцийг тайлангуудад зөрүүтэйгээр тусгасан | 1 | 290.4 | | | 1 | 290.4 | 1 | 290.4 | | | | |
| Дүн | 2 | 732.2 | 0 | 0 | 2 | 732.2 | 2 | 732.2 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | /мянган төгрөгөөр/ | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | | | | | | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлээгүй. | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
2026 оны 02 дугаар сарын 09

6217143681
ИЧТД 0059 9044094